

# “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ын тухай ойлголт, түүний мөн чанар

Б.Жадамбаа


“Орчин” хэмээх ухагдахууны агуулгын хувьсал:

- Ертөнцийн нэгдмэл орны үндсэн төлөв (доод нэгдэл)
- Юмсын үйлчлэлцэн хөдөлж буй “цэг бүрт ижилхэн урсах хугацаа бүхий” орон зай буюу “агуулах сав” (Евклидийн гурван хэмжээст огторгуй — хүрээлэн буй орчин)
- Юм, үзэгдлийн үйлчлэлцэн хувьсаж буй “цэг бүрт орон зай- хугацааны өөр өөр дүр төрх” харгалзах хугацаа, орон зай хоёр шүтэлцэн багцарч, нэг амь болсон орон зай –хугацаа буюу “агуулах сав” (Минковскийн дөрвөн хэмжээст огторгуй –хүрээлэн буй орчин)
- Алив зүйл нь орон зай-хугацаандаа буюу “агуулах сав” -ндаа нэвчин шингэж, нэг болсон амин нэгдэл буюу орон зай – хугацаа – масс -энергийн шүтэлцэн багцрахуй (Римины “муруй” огторгуй: Масс - энергийн түгэлтийн огторгуй хугацаа)
- Ертөнцийн нэгдмэл орны хөгжсөн төлөв (Дээд нэгдэл)

Ертөнцийн нэгдмэл орон: цэг бүр нь эрчим хүчний өөр өөр шинж төрх бүхий төлөвүүдийг (орнуудыг) илэрхийлдэг, хил хязгааргүй боловч төгсгөлөг, үргэлж тэлж байдаг огторгуй-хугацаа буюу нэг амин нэгдэл



Тогтвортой хөгжил - ертөнц хувьсахуйн  
диалектикийн нэг үе шат:




Орон зай, хам хүрээ, орны агуулга:

- Орон зай: байгаль - нийгмийн (сав ба шим ертөнцийн) нэгдмэл огторгуй буюу огторгуй - хугацаа
- Хам хүрээ - тухайн юм, үзэгдлийг төрүүлсэн, түүнтэй хүйн холбоотой байгаль - нийгмийн Нэгдмэл орны үндсэн төлөв
- Орон - цэг бүр нь өөр өөр эрчим хүчний төлөвийг илэрхийлдэг, хил хязгааргүй бөгөөд төгсгөлөг огторгуй - хугацаа

Ертөнцийн нэгдмэл орон, түүний бүрдүүлбэрийн хувьслыг  
судлах аргазүй:

- Бүрдүүлбэр бүр өөр өөрийн гэсэн оронг буюу төлөвүүдийн багцрахуйгаар илэрхийлэгддэг.
- Бүрдүүлбэр бүр нь өөр бүрдүүлбэр бүртэй бус, Тэдгээрийн үүсгэсэн бүх орнуудын нийлбэр оронтой буюу ертөнцийн нэгдмэл орны үндсэн төлөвтэй харилцан үйлцлэлдэг.



Ертөнцийн нэгдмэл орны хөгжлийн экологи – билиг болох байгалийн (сав ертөнцийн) ба арга болох нийгмийн (шим ертөнцийн) нэгдмэл орнуудын эелдэхүй, түүний үр:



Ертөнцийн нэгдмэл орны экологи – ертөнцийн нэгдмэл шинж бөгөөд байгаль ба нийгмийн нэгдмэл орнуудын нэгдэл буюу шүтэлцэн багцрахуй

### **Ертөнцийн хөгжлийн нэгдмэл шинжийн хувьслын диалектик:**

Ертөнцийн хөгжлийн нэгдмэл шинж буюу экологи нь арга болох нийгмийн нэгдмэл орноо даган билиг болох байгалийн нэгдмэл орон нь хөдлөнги, билиг болох байгалийн нэгдмэл орноо түшин арга болох нийгмийн нэгдмэл орон зогсонги болох замаар хувьсан өөрчлөгддөг. Арга болохынхоо хувьд, нийгмийн нэгдмэл орон нь ертөнцийн нэгдмэл шинжийн хувьслын эрч буюу хөдөлгөгч хүч болж байлаг.


### **Нийгмийн хөгжлийн нэгдмэл шинж буюу экологи – нийгмийн орчны ба хүмүүсийн хөгжлийн шүтэлцэн багцрахуй, түүний үр**

- Нийгмийн хөгжлийн экологи нь хүмүүсийн хөгжлийг даган нийгмийн орчин хөдлөнги, нийгмийн орчноо түшин хүмүүсийн хөгжил зогсонги болох замаар хувьсч өөрчлөгддөг.
- Хүмүүсийн хөгжил нь нийгмийн хөгжлийн экологийн эрч буюу хөдөлгөгч хүч болж байдаг. (“Нийгэм гэдэг бол хүмүүсээс өөр юу ч биш” - Францын гүн ухаантан Ж.Руссо, )

### **Хүмүний хөгжлийн нэгдмэл шинж нь түүний хүн болохуй ба хүн байхуйн нэгдэхүй, түүний үр**

- Хүмүний хөгжлийн нэгдмэл шинж нь ертөнцийн, байгалийн, нийгмийн хөгжлийн экологийн “цөм” юм.
- Хүмүний хөгжлийн нэгдмэл шинж нь хүн болохуйгаа даган хүн байхуй хөдлөнги, хүн байхуйгаа түшин хүн болохуй зогсонги болох замаар хувьсан өөрчлөгддөг.
- Хүн болохуй нь хүмүний хөгжлийн нэгдмэл шинжийн хувьслын хөдөлгөгч хүч болж байдаг.

### Ертөнцийн хөгжлийн нэгдмэл шинжийн ахиж дэвших үйл, түүний үр- Тогтвортой хөгжил (ТХ)



### Тогтвортой хөгжлийн Боловсрол (ТХБ):

- Ертөнцийн хөгжлийн Нэгдмэл шинжид, уламжлал — шинэчлэлийн нэгдэлд болон "бүгд" нийтлэг нэг ёс жаяг, зүй тогтол, мөн чанартайд түшиглэн хүмүүнийг боловсруулах хүмүн боловсрох үйл, тэдгээрийн эелдэхүй, түүний үр
- Хүмүүний хөгжлийн нэгдмэл шинжийн ахин дэвшихүй, түүний үр
- Суралцахуйн хөгжлийн нэгдмэл шинжийн ахин дэвшихүй, түүний үр


### Тогтвортой хөгжлийн Боловсрол (ТХБ) – ТХ-ийн :

- Макро түвшний ТХБ
- Мезо түвшний ТХБ
- Микро түвшний ТХБ

### Макро түвшний ТХБ:

- Боловсролын хөгжлийн нэгдмэл шинж нь түүний шинэчлэл (даяаршлын хүрээнд сэтгэхүй) ба уламжлалын (дангааршлын хүрээн дэх үйл ажиллагаагаа сайжруулахуй) нэгдэхүй, түүний үр
- Боловсролын хөгжлийн нэгдмэл шинж нь шинэчлэлийг даган уламжлал хөдлөнги, уламжлалаа түшин шинэчлэл зогсонги болох замаар бүтэж, эвдэрч байдаг.
- Арга болохынхоо хувьд, шинэчлэл нь боловсролын хөгжлийн хөдөлгөгч хүч болж байдаг.


Ертөнцийн хөгжлийн нэгдмэл шинжийн ахиж дэвших үйл, түүний үр-Тогтвортой хөгжил (ТХ)



Мезо түвшний ТХБ:

- Хүмүн боловсрохуйн нэгдмэл шинж буюу ТХБ -билиг болох хүншихүй, арга болох суралцахуйн нэгдэхүй буюу шүтэлцэн багцрахуй, түүний үр
- Хүмүн боловсрохуйн экологи буюу нэгдмэл шинж нь суралцахуйгаа даган хүншихүй хөдлөнги, хүншихүйгээ түшин суралцахуй зогсонги болох замаар хувьсан өөрчлөгддөг. Өөрөөр хэлбэл, "сурч эзэмшсэнээ шууд ажил хэрэг болгох замаар хүншиж, хүншсэнийхээ ачаар бусадтай хамтран тэднээс суралцан чадамжаа ахиулж, түүнийг ажил хэрэг болгон хүншихүйн дараагийн шатанд хүрэх" орчил бүхий өргөжин дэвжих спиралын дагуу хүмүн боловсрохуйн нэгдмэл шинж тасралтгүй урагшилдаг.
- Хүмүн боловсрохуйн экологийн хувирал өөрчлөлтийн хөдөлгөгч хүч буюу арга технологи нь суралцахуйн буюу сургалтын нэгдмэл шинж болж байдаг.


Ертөнцийн хөгжлийн нэгдмэл шинжийн ахиж дэвших үйл, түүний үр-Тогтвортой хөгжил (ТХ)



### Микро түвшний ТХБ:

- Суралцахуйн буюу сургалтын нэгдмэл шинж нь арга болох сургахуй, билиг болох сурахуйн нэгдэл, түүний үр
- Суралцахуйн буюу сургалтын нэгдмэл шинж нь сургахуйгаа даган сурахуй хөдлөх (сэдэлших), сурахуйгаа түшин сургахуй зогсох (шинжлэн үнэлэх) замаар бүтэж, эвдэрч байдаг.
- Арга болохынхоо хувьд, сургахуй нь суралцахуйн нэгдмэл шинжийн хөдөлгөгч хүч тал болж байдаг.

### Ертөнцийн хөгжлийн нэгдмэл шинжийн ахиж дэвших үйл, түүний үр-Тогтвортой хөгжил (ТХ)



### Микро түвшний ТХБ-ыг хэрэгжүүлэхүй буюу суралцахуйд сургахуй

Эзэмшүүлэхүй – Суралцахуйд сурах

### Мезо түвшинд ТХБ-ыг хэрэгжүүлэхүй

- Суралцахуйд сурах
- Сурснаа шууд хэрэгжүүлж хүнших

### Макро түвшинд ТХБ -ыг хэрэгжүүлэхүй ба хүншүүлэхүй:

- Хүмүн нь эх дэлхийтэйгээ, хүрээлэн буй байгаль-Нийгмийн нэгдмэл орчинтойгоо эх үрийн буюу хүн холбоотой болох, түүний хууль, зүй тогтол, ёс жаягийг мэдсэний үндсэн дээр түүнтэй харьцаж, өөрөө оршин байж, ажиллаж амьдрах боломжтой гэдгийг мэдрүүлэх, ойлгуулах, ухааруулах, ухамсарлуулах
- Хүмүнийг “юм, юмны захтай болгох” буюу түүнд “бүх ухааны бичиг үсгийн бага, суурь, бүрэн дунд, дээд түвшний бичиг үсгийн боловсрол (бүх ухааны хэлүй)” эзэмшүүлэх замаар суралцахуйд (бүх ухааны чиглэлээр бусадтай бүтээлчээр хамтран ажиллан сурахуй ба сургахуйн нэгдмэл шинжид сургах